

““ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ХХК, “МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ХХК-ИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭ, ҮР НӨЛӨӨНИЙ ТАЙЛАН

Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдөр “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголпросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 23 дугаар тогтоолыг баталж, уг тогтоолын 3 дахь заалтад “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголпросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг Хөгжлийн банк болон Монголбанкнаас Худалдаа хөгжлийн банкинд байршуулсан мөнгөн хөрөнгө, ногдол ашиг, вексель зэрэг эх үүсвэрээс суутган тооцох хэлцэл хийж төрийн өмчид авах арга хэмжээг зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 151 тоот захирамжаар байгуулсан ажлын хэсэг “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголпросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг худалдан авсан гэх талтай хэлэлцээрийн хүрээнд дөрвөн удаагийн уулзалт, хэлцлийг зохион байгуулан, санал боловсруулж “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголпросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг худалдан авсан гэх талд танилцуулсан боловч хүлээн зөвшөөрөөгүй болно.

Иймд хэлцлийн үр дүн, ажлын хэсгийн санал дүгнэлтийг Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Улмаар Засгийн газрын “Хувьцааг төрийн өмчид бүртгэх, холбогдох төлбөрийг суутган тооцох тухай” 7 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголпросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцаанд төлсөн 400.27 сая ам.долларыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Оросын талд олгохоор зарласан ногдол ашиг, Монголбанк, Хөгжлийн банкнаас Худалдаа хөгжлийн банкинд олгосон зээл, байршуулсан мөнгөн хөрөнгө, Хөгжлийн банкнаас “Кью Эс Си” ХХК-д олгосон зээл, “Кью Эс Си” ХХК-ийн авто зам, төмөр замын концессын төлбөрт олгосон санхүүжилт, векселийн төлбөр зэрэг эх үүсвэрүүдтэй суутган тооцож, “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголпросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг төрийн өмчид бүртгэн авахаар шийдвэрлэсэн.

“Монголиан коппер корпорейшн” ХХК тус Засгийн газрын тогтоолыг эс зөвшөөрч Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гарган 3 шатны шүүхээр хэлэлцсэний үр дүнд Дээд шүүхийн захиргааны хэргийн 2018 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 329 тоот тогтоолоор *“...хэлцэл хийх замаар төрийн өмчид авах арга хэмжээг зохион байгуулаагүй нь холбогдох хууль тогтоомжид нийцээгүй...”* гэж дүгнэн нэхэмжлэгчийн шаардлагыг хүлээн авч шийдвэрлэсэн.

Ийнхүү Засгийн газраас Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор суутган тооцох хэлцэл хийж төрийн өмчид авах чиглэлээр боломжтой бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч хэлцэл амжилтгүй болсон.

Иймд Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор тус тогтоолд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай байна.

Нэг.Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн “Монгол Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаар тогтоолд “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад Монгол Улсын иргэн “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. ...” гэж заасан билээ. Аливаа хөдлөх, үл хөдлөх хөрөнгийг хуулийн дагуу эсвэл хууль зөрчигдсөнийг мэдээгүй, эсвэл хууль зөрчигдөж байгааг мэдэх бололцоогүй байсан нөхцөлд л шударгаар олж авсанд тооцох боломжтой. Гэтэл Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс үзэхэд “Монголиан Коппер Корпорейшн” ХХК-ийн төлөөлөл гэх Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх захирал О.Орхон “... хуулиар бол энэ гэрээг баталсан, энэ гэрээ нь өөрөө өөрийгөө хүчингүй болгох ийм заалттай учраас дахиж энийг оруулах, соёрхон батлуулах зөвшөөрөл шаардлагагүй гэж бид үзэж дүгнэлтээ гаргаж байгаа. ...” гэж байсан нь хуулийн шаардлагыг урьдаас мэдэж байсныг харуулж байна.”, “Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хууль болон бусад хуулийн холбогдох заалтыг зөрчсөн шийдвэрийг үндэслэл болгон хийсэн хэлцлээр шилжүүлсэн өмчлөлийн зүйлийн хувийн өмчийн эрх холбогдох этгээдэд шударгаар үүссэн гэж үзэх, энэхүү эрхийг хамгаалах хууль зүйн хангалттай үндэслэл бүрдээгүй байна.” гэсэн үндэслэлүүдээр “Монгол Улсын Их Хурлын “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь ... хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;”, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.”, “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг төрийн мэдэлд авсан тохиолдолд “Монголиан Коппер Корпорейшн” ХХК-ийн Оросын Холбооны Улсын “Ростех” корпорацид уг 49 хувийн энгийн хувьцааг авахад зарцуулсан төлбөрийг төлж барагдуулах үүрэгтэйг дурдсугай.” гэж тус тус дүгнэсэн.

Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал

“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангахад энэ тогтоолын зорилго оршино.

Тогтоолын төсөл нэг зүйлтэй байна.

Тогтоолын төслийн нэгдүгээр зүйлд: ““Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолын 3 дахь заалтын “суутган тооцох хэлцэл хийж” гэснийг “суутган тооцож” гэж өөрчилнө.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсанаар гарах үр нөлөө

Тогтоолын төсөл батлагдсанаар ““Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах боломжтой болно.

Тогтоолын төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засагт үзүүлэх ямар нэгэн нөлөө байхгүй.

САНГИЙН ЯАМ